Pax Mongolica №1, 2015 он:50-69 хуудас

1911 оны Монгол Тусгаар тогтнол ба Монгол овогтон нэгдэхийн төлөө тэмцсэн нь

О.Батсайхан[1]

1911 оны 12 дугаар сарын 29-ны өдөр Монголчууд Манж гүрнээс салж, бие даан тусгаар тогтносноо дэлхий дахинд албан ёсоор зарлаж, Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хаанаар өргөмжилсөн билээ.[2]

Тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөөний үнэ цэнийг эл өдрүүдэд монголчууд үнэхээр их хүсэж байсанаа мэдэрч, монгол хүн бүрийн магнай тэнийж, сэтгэлд нь нар гийсэн хэмээн настай буурлууд дурссан нь буй.

1911 оны үндэсний хувьсгалын талаарх уламжлал, гадаад, дотоодын олон эрдэмтдийн бүтээлийн ололтонд түшиглэн 2011 оноос эхлэн монголчууд жил бүрийн 12 дугаар сарын 29-ны өдрийг үндэсний тусгаар тогтнолоо сэргээсэн баярын өдөр болгон тэмдэглэж байна.

1911 оны 12 дугаар сарын 29-ны өдөр монголчууд төр улс, тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан түүхэн үйл явдал хийгээд монгол олон овогтон эл үйл явдалд хэрхэн оролцож, нэгдэхийг оролдож байсан талаар товч өгүүлье.

Түлхүүр үг: *Монгол улс, Богд хаан, тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөө, монгол овогтон, дагаар орсон монголчууд*

1.ШУА-ийн Олон Улсын Харилцааны Хүрээлэнгийн ЭШТА, доктор (Sc.D), профессор
bagi112005@yahoo.com

2. О.Батсайхан Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог, Хөөр дахь хэвлэл, УБ., 2011 он.

Монгол Үндэсний Хувьсгалын Оргил - 1911 оны 12 дугаар сарын 29-ны өдөр тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан нь

VIII Богд Жавзандамба хутагтын санал, санаачилга, удирдлага дор Монголчуудын Манж Чин улсаас тусгаарлах тэмцэл үргэлжилсээр түүний оргил болж, 1911 оны 12 дугаар сарын 29-ны өдөр тусгаар тогтнолоо албан ёсоор тунхаглан зарлав.

1911 оны 12 дугаар сарын 29–ны өдөр ямар өдөр байв.

Европ тооллын 1911 он, Дайчин хэмээх Манж улсын Хэвт ёсны гуравдугаар он, Монголын арван тавдугаар Рабжунгийн цагаагчин гахай жилийн өвлийн дундад сарын шинийн есний өдөр бөгөөд төрийн их ёслолыг гүйцэтгэх маш сайн өдөр хэмээн сонгон үзэж тодруулсан, хишиг гариг, усан тахиа өдөр[3] байжээ. Архивын эх сурвалжид тэмдэглэснийг үзвээс, Халхын Хүрээний газрын бүгд хэргийг түр захиран шийтгэх газраас Дөрвөн аймгийн чуулганы дарга, жанжин нар, Хүрээний хамба, хутагт хувилаад, хан ван гүн олон засгууд, лам нарт хандан Цагаагчин гахай жилийн Өвлийн тэргүүн сарын 17-нд илгээсэн бичигт өгүүлэхдээ: “Очир дара Богд гэгээнтэнийг манай Монгол Улсын хаанд өргөмжилж, эрдэнийн сууринд залж, ёслон мөргөж, их төрийн ёслолыг гүйцэтгэх маш сайн өдрийг сонгон үзүүлбээс энэ Цагаагчин гахай жилийн 11 сарын 9 нь Баасан гариг усан тахиа, энэ өдрийн морин цагийн эхний хувьд өлзий учрал бүрдсэний тул энэ цагт өргөмжлөл, ёслолыг гүйцэтгэвээс”[4] сайн хэмээн лүндэн зарлиг буусан хэмээжээ.

Гадаад, дотоодын эрдэмтдийн бүтээлд эл өдрийг 11 дүгээр сарын 9, 12 дугаар сарын 15 эсвэл 16, мөн сарын 26, 28 гэх зэргээр янз бүрээр бичсэн тааралдах бөгөөд Оросын шинэ тооллоор үзэх аваас эл өдөр нь яах аргагүй 1911 оны 12 дугаар сарын 29-ны өдөр таарч байгаа юм.

Хугацаа: Энэ өдрийн морин цагийн эхний хувьд буюу 11 цаг 40 минутад өлзий учрал бүрдсэний тул энэ цагт өргөмжлөн их ёслолыг[5] гүйцэтгэхээр олон монголчуудад мэдэгдэн эхлүүлж орой нар шингэхийн

3. В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг, Судлан хэвлүүлсэн акад.Б.Ширэндэв, эрхэлсэн акад.Ш.Нацагдорж, УБ., 1972, 102 дахь тал
4. Үндэсний төв архив Ф.388, д.2, х.н.33 64 дэх тал
5. В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг, Судлан хэвлүүлсэн акад.Б.Ширэндэв, эрхэлсэн акад.Ш.Нацагдорж, УБ., 1972, 102 дахь тал

өмнө буюу оройн 5 цагийн орчим[6] өндөрлөсөн байна. Богдыг Монгол Улсын эзэн хаанд залах төрийн их ёслол энэ өдрийн морин цагт 11.40 эхэлсэн ба орой гэгээ тасраагүй үед дууссан хэмээн үзвэл ёслолын ажиллагаа 5 цаг гаруй үргэлжилсэн хэмээн үзэж болмоор.

Хаана: Уг үйл явдалд өөрийн биеэр оролцсон Г.Наваанамжил авгайн өгүүлснээр[7]: "Богдын орд хашааны дотор бий Дэчин галбын дуган гэдэг алтан дээвэртэй сүмийн зүүн тал, мөн Дорждвааран гэдэг дуганы баруун талын хэсэг сул газрын шар хашааг хойш тэлж ихтгэн, тэрхүү зайд, Монголын төрийн орд гэдэг шар хамба торгоор өнгөлж, хөх торгоор мөшгөөрлөсөн, сүлбэмэл очир есөн эрдэнэ, долоон тахил гэх мэтээр гоёмсоглож хээлсэн арван хэдэн ханатай том эсгий гэрийг байгуулав" гэжээ. Төрийн шар ордон нь эдүгээгийн Урлан бүтээх төвийн орчим байрлаж байсан байх бөгөөд Богд хаан Туулын хөвөөнд буй түүний өвлийн хоёр давхар[8] ордонгоос хатаны хамт Төрийн ордон руу ирсэн байна.

Богд хаан, эх хатан нарыг Монгол Улсын эзэн хаан, эх дагина дор өргөмжилж Засгийн газрыг байгуулж, хишиг тараах ёслолыг гүйцэтгээд Их Хүрээний Цогчин дуганд Богд, эх дагина олон сайд, ноёд, лам нар морилж очин Даншиг хуруулж, мандал өргөсөн байна. Үүний дараа буцаж, төрийн ордонд очиж орой болоход мөн их ёслол жагсаалаар дээд сүмийн зүг буцаж энэ өдрийн ёслол дуусч тарсан ажээ.

Ёслолыг Төрийн ордонд эхлээд Цогчин дуганд мандал өргөөд эргэж Төрийн ордонд дуусгасан нь төр, шашины зохицоог илэрхийлэхийн хамт Төрт ёсны уламжлалыг давуутайд үзсэнийг нотлох болов уу[9].

Төрийн их ёслолын үйл ажиллагаа:

Энэ үйл явдлын талаар уг ёслолын ажиллагаанд оролцогчийн байр сууринаас бичиж үлдээсэн, маш сонирхолтой бүтээл бол Г.Наваанамжил авгайн Өвгөн бичээчийн өгүүлэл[10] болой. Тэрээр бичихдээ: "Мөнөөхөн өвлийн дунд сарын шинийн есөн болж ирэв.

6. Харбинская газета "Новая жизнь" 4 Января 1912 года
7. Г.Наваанамжил Өвгөн бичээчийн үгүүлэл, УБ., 1956: Улсын хэвлэлийн газар
8. Энэхүү Богдын хоёр давхар ордонг оросууд түүнд барьж өгсөн хэмээдэг билээ.
9. Эрхид Гомбосүрэн Д. Түүвэр зохиол., 1, Монголын түүх судлалын өгүүллүүд, УБ.,2005, 25 дахь тал
10. Г.Наваанамжил Өвгөн бичээчийн үгүүлэл, УБ., 1956: Улсын хэвлэлийн газар

Мөнхүү өглөө чуулганы даргын жасааны түшмэл, бичээч нарын хамт залан Дашдондов, Анваан[11] нар малгай, хүрэм болон Их Хүрээний төвийн шар ордоны тэнд очиж, мориноос буугаад их хаалганы өмнө хүрэхэд олон хүн хуралдаж, үнэхээр нүд алдам их байв. Отго жинс хүрэм эрээн дээлтэй ноёд, түшмэд, хутагт хувилгаад, лам нар жагсан хүлээж байна. Тэдний дунд ороод байтал удалгүй дээд сүм дээр Гурван их буу тавьсан чимээ түжигнэж сонсдоно.

Богд, Цагаан дарын хамт их ёслолоор явж ирэхэд тэдгээр хуралдагсад сөгдөн, нам гүм. Богд хатны хамт, шар өнгөтэй алтан туг бүхий дөрвөн дугуйтай гоё орос тэргэнд сууж, хиа лам найман хүн тэргийг дамнан хөтөлж явна. Өмнө нь донир, сойвон, бараа бологч зэрэг том лам нар жагсан явах ба улаан хуйтай сэлэм зүүсэн хоёр гурван хар ноён зам удирдана. Олон шадар цэрэг замын хоёр талаар буу зэвсэгтэй, ёслолын хувцастай жагсан явна. Богд, хатны хамт шар ордны дунд хаалгаар явж, орд гэртээ ормогц тэдгээр ноёд, лам нар цөмөөр дагалдаж ороод шадар ихээхэн ноёд, лам нар нь бүгд орд гэрт орж очсон байна. Бусад ноёд нь төрийн ордны өмнө зогсож хүлээнэ. Их, бага түшмэд ба ялангуяа бичээч нар ордны үүдний дотор талд чихэлдэн зогсож, ямар ч ажилгүй дэмий л биеэ жихүүцүүлэн холхиж байна. Ордны гадаад үүд, улаан шөргийн дотор ба гадна мөн сайныг цэнгэлдэхэд дуртай хэмээх алтан үсгийн илэрхийлэл бүхий ногоон ваартай юаньпайн хойд талаар үй олон энгийн лам, хар ард цугларан үймэх нь үнэхээр шинэ нээсэн шоргоолжийн үүр мэт бөгөөд бургас мод барьсан хаалгач лам нар, хиа, цагдаа нар эдгээр хүнийг эсрэг тэсрэг хамаагүй жанчиж, шавхуурдаж, тарианд орсон хонь мал мэт ийш тийш хөөгдөвч Богдыг хаан сууна гэхэд мухраар хэтэрхий биширч, жанчигдаж, гөвшигдөвч, дэмий л ордны үүдний зүг харуулдаж аливаа нэгэн сонин сайхан юм үзэхсэн гэж горилох байдалтай шуугина”[12] хэмээснээс үзвэл Богд гэгээн, хатны хамт болзсон цаг болохоос арай өмнө Өвлийн ордоносоо ирж, Төрийн ёслолын хувцас, хэрэглэлээ өмсөж бэлдсэн хэмээн үзэж болохоор ажээ.

Тэрбээр цааш өгүүлрүүн: “Үдийн үе болоход ордны зүүн тасалгаанд бий Богдын тугдам гэдэг гэрийн үүднээс эхлэн төрийн

11. Г.Наваннамжил гуай өөрийгөө ийнхүү нэрлэсэн буй.
12. Г.Наваннамжил Өвгөн бичээчийн үгүүлэл, УБ., 1956: Улсын хэвлэлийн газар

ордны хоймор байгаа дөрвөн арсланы дүрсийг сийлж түшүүлсэн элдэв алтан хээт хааны ёслолын өндөр тавцан бүхий олон давхар магнаг олбог түшлэг хүртэл ба мөн Очирдара гэдэг гэр дуганд замнаж оруулах, хүн явж багтах нарийхан банзан шалтай, шар торго дэвссэн зам “гардан”-ыг бэлтгэв.

Богд, эх дагина хоёр хар үнэг гэдэг үнэт үстэй малгайд очир жинс хадаж, эрээн дээл, булган цоохор хүрэм өмсөж, явганаар шадар ноёд, сойвон, донир нарыг дагалдуулан хойноо шар торгон ба алтан саа луу хээт шүхэр хоёр тогосны өдөн шүхэр нэг, ийм гурван шүхрийг бариулж, өмнө нь донир ба улаан хуйт сэлэм зүүсэн хар ноён хоёр хүн удирдан, мөнөөхөн бэлтгэсэн шар торгон зам дээгүүр алгуурхнаар алхуулан явахад нь шадар ноёд дөрвөн хүн Богд, эх дагинын хоёр талаас нь түшиж хүндэтгэн явна. Ордны дотор их буу гурван удаа тавьж, нижигнэн түжигнэхэд ордны дотор байсан зарим аймтгай шадар хүмүүс нь цочиж уулга алдаж бархирна. Энэ уулга алдах гэдэг нь үнэнгүй худал бөгөөд Богдод таалагдахын арга болно. Богд, эх дагинын хамт Очирдара гэдэг дуганд ороод хойш явж төрийн ордонд орж очив. Төрийн ордонд бараалхан орох эрх бүхий ихээхэн хутагт хувилгаад, хан, ван, бээл бээс гүн засаг тайж нар цөм дагалдан орцгоов. Эрх, хувьгүй түшмэл, бичээс над дэмий л гадна хүлээн чичирч, төрийн ордны үүдэнд хүрч юм үзэх гэх ба ийш тийш явья гэвч, бургас мод барьсан хаалгач лам, цагдаа нар хориглож донгодох ба бургас модны хишиг хүртэх учир явж хөдөлж чадахгүй, ямар ч хэрэггүй дэмий чичрэлдэн, хэзээ ёслол тарахыг хүлээж байх нь тэр үеийн дээд доодын эрх тэгшгүй байдал илэрхий мэдэгдэнэ.

Анваан, мөнөө түшмэл, бичээч нарын хамт даарч, чичирч, юм үзэх, сонсохсон гэж өндөлзөн байтал, төрийн ордноос хуучин хүрээний монгол сайд байсан бэйс Пунцагцэрэн гартаа нэлээд том бичиг барьж ирээд хишиг тараах зарлиг буув гэж өндөр дуугаар хэлнэ. Мөнөө түшмэл, бичээч зэрэг хар лам хүмүүс цөм чимээ аниргүй болон сөгдөнө. Бээс Пунцагцэрэн тэрхүү хишиг тараах зарлигийг уншиж л байв. Үг нь ер тодорхой сонсдохгүй, чинээгээрээ чих тавьж сонсвол: Богдыг Монгол Улсын наран гэрэлт түмэн наст Богд эзэн, Цагаан дарыг улсын эх гэж өргөмжилж, оны цолыг Олноо өргөгдсөн гэж нэрийдэж,

Их Хүрээг улсын төв Нийслэл Хүрээ болгон Монгол улсыг байгуулж, дэлгэр их ёслолыг явуулав[13] хэмээжээ.

Богд хааны монгол бичгийн багш Хурц Магсаржав бичихдээ: "Монголын төрийн орд, Дотоод, Гадаад, Цэрэг, Сан, Шүүх таван яамны байгуулалтыг урьдаар засацгаан бэлтгэхэд төв гэрүүдийг цөм монгол гэр үйлдэн байгуулаад Монголын цагаагчин гахай жилийн 11 дүгээр сарын шинийн 9 бөгөөд Европын 1911 оны 12 дугаар сарын 16 (29–О.Б)-ны өдөр Богд Жавзандамба хутагт ламыг Монгол Улсын хаанд өргөмжлөх явдлыг гуйн айлтгаж мөн өдрийн 11 цагт эрдэнийн ширээнд залж суулгаад басхүү шавь охин эрдэнэ сэцэн Цагаан Дара Дондогдуламыг улсын эхэд өргөмжлөн хамтаар ёслох учир хааны эрдэнэ, хасын тамга, алтан үсэгт өргөмжлөл ба Монголын газраас гарсан ёсны юм есөн цагаан билгийн[14] цагаан тэмээ, мөнгөн буйл, булган мулцагт нижгээд цагаан морь, булган мулцагт наймаад хадаг сэлтийг бэлэглэн өргөхдөө төрийн ордоноо хуралдсан хүн бүгдээр хичээнгүйлэн Богд хаан, Улсын эхэд тус тус гурвантаа сөгдөж, есөнтөө толгой дохиж"[15] мөргөсөн хэмээжээ. Тэрбээр цааш өгүүлэхдээ: "Богд Жавзандамба хутагтыг хаанд өргөмжилсөн нь олон монголчуудын итгэж бишрэх нийтийн санаанаас гарсаны тулд улсын цолыг Монгол, оны нэрийг Олнаа өргөгдсөн хэмээн нэрийдсэн Монголын цагаагчин гахай жил, европын 1911 оны Олнаа өргөгдсөний тэргүүн он болгон тогтоов"[16] хэмээсэн буй.

Манжич Л.Дэндэв 1911 онд Монгол тусгаар тогтносон явдлыг «манжаас хагацаж өөрийн үндэс язгуурыг хамгаалан олон улсын дунд тусгаар чанартай улсын засгийг явуулсан гайхамшиг түүхтэй их хэргийг бүтээсэн» хэмээн дүгнэж, энэ үеийн чухал үйл явдлуудыг бүтээлдээ тод томруун тусгасан буй.

Монголын энэхүү түүхэн үйл явдлын талаар гадаадын эх сурвалж, эрдэмтэн судлаачдын бүтээлд юу хэмээн бичсэнийг сонирхцгооё.

Хүрээнд сууж байсан Оросын консул Лавдовский 1911 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Гадаад яамандаа илгээсэн 1234 тоот нууц

13. Г.Наваанамжил Өвгөн бичээчийн үгүүлэл, УБ., 1956: Улсын хэвлэлийн газар, 182-185 дахь тал
14. Нэгэн цагаан есөн цагаан билгийн үнэ 280 лантай тэнцэж байжээ.- ҮТА. Ф.А3, д.1, х.н.369, х.5
15. Н.Магсаржав Монгол Улсын шинэ түүх, УБ., 1994, 12 дахь тал
16. Н.Магсаржав Монгол Улсын шинэ түүх, УБ., 1994, 33 дахь тал

цахилгаандаа: “Өнөөдөр Халхын ноёдууд олон хүн оролцсон баяр ёслолын цуглаан дээр Гэгээнийг Бүх Халхын хаанаар өргөмжиллөө”[17] хэмээн мэдэгдсэн байна. Оросын консул товч бөгөөд тодорхой ийм мэдээг Засгийн газартаа уламжилсан байна.

Оросын сэтгүүлч И.И.Ломакина бичихдээ[18]: “Өглөөнөөс бүхнийг хамарсан өргөн цуглаан эхэлж, түүнд бүх л дээд лам нар, цэрэг, хоёр мянга орчим зэвсэглэсэн казакууд оролцож, жагсаалаар Богдын өвлийн ногоон ордоноос Хүрээ рүү хөдлөв. Богд болон түүний эхнэрийг хүүгийн хамтаар шар өнгөтэй хаалттай сүйхэнд суулган өргөж, баяр ёслолд зориулан алтан болон шар өнгөөр бүрсэн асар том гэр хүрч, тэндээсээ Ордон руу шар өнгийн материалаар зассан замаар явав. Замын хоёр талаар ноёдууд жагссан байв. Гэрийн хойморт хос сэнтий зассан байв. Ийм байдалтайгаар цогчин дуган орж, товчхон мөргөл үйлдээд буцаад ордондоо заларсан. Баяр ёслолын байдалтай нам гүм байдалд Хаан эзний сууринд залах тухай тунхагийг уншиж, Богд болон түүний эхнэрийн толгой дээр Да лам, Сайн ноён хан нар титэмийг өмсгөсөн. Алтан очир нь Чингис хааны үр сад сэргэсэнийг илэрхийлж байв. Ийнхүү их бууны дуутай зэрэгцэн хаан суудалд засах ёслол болжээ. Үүний дараа бэлэг өргөн баяр хүргэх үйл явц эхлэв. Үүний дотор гол нь есөн цагааны бэлэг орж байв. Энэ өдөр есөн цагааны бэлэг ердийнхөөс 100 дахин илүү өргөж, бүгд цагаан хадаг барьсан байв. 900 цагаан тэмээний хүзүүн дээр булга, хар үнэг болон бусад зэрлэг үнэт амьтдын арьс өлгөөстэй байв. Өргөл бэлэг хошуу бүрээс, томоохон ноён бүрээс, Хүрээний хятадуудаас өгч, заримдаа мөнгөн эдлэл, торгон хувцас бэлэглэж байжээ.

Төрийн ёслолоос хоёр цагийн дараа хааны гэр бүл дахин мөргөл хийхээр нээлттэй сүйхэнд суун, Майдар сүм рүү явсан байна. Дагалдсан ноёд, лам нар бүхий л хугацаанд асаасан лаа барьж явав. Цуваа их бууны дуун дор явж байв. Мөргөл үйлдсэний дараа буцаж, ордондоо залраад хишиг тарааснаар энэ өдрийн ёслол оройн 5 цагт өндөрлөж, Хаан эзэн, улсын эх дагины сууринд суусан Богд, түүний

17. Архив Внешней политики Российской империи ф.Китаский стол 143, Опись 491, д.644, с.388
18. И.И.Ломакина Монгольская столица, старая и новая, Сфера Евразии, Товарищество научных изданий КМК: 2006, с.65;

эхнэр тус тусдаа хаалттай сүйхэнд сууж, өөрийн ордондоо залрав"[19] хэмээн бичжээ. Хааны ийнхүү явж байхад өнгө өнгийн туг дохиур барьсан түшмэлүүд дагалдаж, замын дагуу ард олон өвдөг сөхрөн мөргөж өөрийн хаандаа хүндлэл илэрхийлж байсан. Хааны ногоон ордоны гадаа сүйхээс нь буухад их буу дахин буудаж байв. Ийнхүү Олноо өргөгдсөний эзэрхлийн үе эхлэв хэмээн мөн тэнд бичжээ.

Хүрээнд сууж байсан Оросын ерөнхий консул В.Ф.Люба Петербургт илгээсэн 1912 оны 1 дүгээр сарын мэдээндээ "Хэзээ нэгэн цагт Монголын сүүлчийн жилүүдийн түүхийг бичих болбол түүхнээ Хамгийн аймшиггүй ухаантан ч энэ тухай бодохыг зүрхлээгүй тийм зүйлийг хэрэгжүүлэгч VIII Богд гэгээний зоригтой, шийдвэртэй санаачилгыг талархалтайгаар тэмдэглэх болно"[20] хэмээн онцлон тэмдэглээд цааш өгүүлэхдээ: "Монголыг эдүгээ эрх чөлөөтэй залгуулсан энэ үйл хэргийг манлайлсан хүн нь яах аргагүй Хутагт мөн"[21] гэсэн буй.

Түүхэн энэ цаг үед Хутагт ард түмнийхээ хүсэл зоригийг соргогоор мэдэрч, Хятадаас холбоогоо таслахаар шийдэж, Монголын хувьд хэзээ нэгэн цагт байсан шиг нь хүчирхэгээр хамгийн дээд өндөрлөгтөө зогсож, Их Орос улсаас тусламж эрсэн[22] юм хэмээн консул Люба нэмж тэмдэглэсэн байна.

Харин Оросын зарим эрдэмтэд "1911 онд Монголд тусгаар тогтносон улс байгуулагдсаны үр дүн болж, Орос орон өөрийн хөрш Монголтой шинэ харилцаа үүсгэн байгуулсан нь XX зууны нэг ололт юм" гэсэн буюу "Монголд 1911 онд тусгаар тогтносон улс байгуулагдсан явдал нь тус бүс нутагт олон улсын шинэ нөхцөл байдлыг тодорхойлох болсон юм"[23] хэмээн дүгнэсэн байна.

---

19. Харбинская газета "Новая жизнь" 4 Января 1912 года
20. РГИА., ф.892, оп.3, ед.хр.127, л.1, Архив Внешней политики России, Фонд Миссия в Пекине, Опись 1, Дело 316
21. РГИА., ф.892, оп.3, ед.хр.127, л.1, Архив Внешней политики России, Фонд Миссия в Пекине, Опись 1, Дело 316
22. И.И.Ломакина. Монгольская столица, старая и новая, Сфера Евразии, Товарищество научных изданий КМК: 2006, с.64
23. Жизнь и научная деятельность С.А.Кондратьева (1896-1970): в Монголии и в России, Подготовка к изданию, предисловие, введение, комментарии и указатели- И.В.Кульганек, В.Ю.Жуков, Санкт-Петербург, 2006, с.10

Японы монголч эрдэмтэн Наками Татсуо “1911 оны 11 дүгээр сарын сард Хүрээнд сууж байсан Манжийн амбан хөөгдөж, 1911 оны 12 дугаар сарын 1-нд Халх Монголын хан ван гүнгүүд тэдний улс төрийн тусгаар тогтнолоо тунхаглав. Харин шинэ засгийн газар албан ёсоор 1911 оны 12 дугаар сарын 29-нд байгуулагдаж, Жавзандамба хутагтыг эзэн хаан хэмээн өргөмжилсөн”[24] гэж бичжээ.

1911 оны Монголын үндэсний хувьсгалын үйл явдлыг өөрийн нүдээр ажигласан Хятад дахь Англи, Америкийн тамхины пүүсийн төлөөлөгч Т.А.Рустад энэ үеэр Хүрээнд ирээд Английн таймс сонины Бээжин дэх сурвалжлагч Моррисонд 1912 оны 11 дүгээр сарын 5-нд бичсэн захидалдаа: «Энэ нь Манжийн засгийн газрын эсрэг боссон хятадын хувьсгалын үргэлжлэл биш бөгөөд Монголд болсон биеэ даасан өөр нэг хувьсгал юм» хэмээн дүгнэсэн нь Монголчуудын үндэсний тэмцэл хэр зэрэг их нөлөө бүхий байсаныг илтгэн харуулсан хэрэг юм.[25]

Монгол овогтон нэгдэхийн төлөө тэмцсэн нь

Энэ үеэр Өвөр Монголд үндэснийхээ тусгаар тогтнол эрх чөлөөний төлөө, монгол овогтон эвлэлдэн нэгдэхийн төлөө хятадуудын дарлалыг эсэргүүцсэн тэмцэл газар сайгүй үргэлжлэн өрнөж, 1911 онд тунхаглан зарласан Богд хаантай Монгол улсын төрд дагаар орох саналаа Өвөр Монголын 49 хошуунаас 35 нь илэрхийлээд байсан үе байлаа.[26] Сүүлийн үеийн судалгаагаар Өвөр Монголын 49 хошууны 38 нь лав Богдын Засгийн газарт орохоо илэрхийлсэн[27] хэмээн Өвөр Монголын эрдэмтэн Өргэдэй Тайбун бичсэн буй.

Энэ нь Богд тэргүүтэй Монголын засгийн газраас Өвөр Монгол зэрэг монгол үндэстнийхээ талаар явуулсан бодлого, үйл ажиллагааны үр дүн байв. Богд хаанаас Өвөр Монголын ард олонд хандан гаргасан

24. Nakami Tatsuo. Russian diplomats and Mongol Independence, 1911-1915, - Mongolia in The Twentieth century: Landlocked Cosmopolitan, Ed. By Stephen Kotkin and Bruce Elleman, NY and London: M.E.Sharpe, 1999, p.74

25. Удо Б.Баркманн. Монголын түүх судлалд хувь хүний архив сонин баримт болдогийн нэгэн жишээ Ж.Моррисон –1911 оны Монголын үндэсний хувьсгалын 90 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл 2001.12.14

26. Ш.Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа 1850 –1919.,Тэргүүн дэвтэр, УБ., 1971 он

27. Өргөдэй Тайбун. Хорьдугаар зууны эхний Өвөр Монголын улс төрийн хувьсалтын түүх, Үхэр жилийн үймээний гэрэл ба сүүдэр, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2006 он, 318 дахь тал

зарлигт өгүүлэхдээ «манай Монгол өвсөбэн нэг улс байгуулж шарын шашнаа хамгаалж бусдын эрх сүрээр дарах зовлонг амсахаас зайлсхийх хэрэгтэй. Нэгэн сэтгэлээр хүчээ хамтатгаж өөрийгөө хамгаалахаар хүчлэн чармайх хэрэгтэй», «Тусгаар тогтнохоос өөр оршин тогтнох зам үгүй» болохыг ухуулахын зэрэгцээ «өвөр Монголын эл хошууд урьд хожид бичиг ирүүлээд дуртайяа дагах гэж илэрхийлсэн» явдлыг сайшаан тэмдэглэж, цаашид Өвөр Монголын хошууны монгол ван гүн нар Монголын засгийн ордонд даган орох аваас найман зүйлийн хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийг мөн зарлигийн хамт илгээж байжээ.

Эдгээр найман зүйл юу байв хэмээвээс

1. Аялдан дагасан өвөр Монголын ван гүн нарын одоогийн тушаалыг уг хэвээр үлдээж, жилийн пүнлүүг нь бүр Хүрээний засгийн ордоноос хувь дахин илүү өгнө.

2. Ван гүнгээс доошыг нь бүр нэг зэргээр дэвшүүлж жилийн пүнлүүг нь Хүрээний засгийн ордоноос өгнө.

3. Эл хошууны засгийн зардал болон цэргийн зардал хүрэлцэх үгүй байвал Хүрээний засгийн ордоноос зохистойгоор нөхвөрлөж өгнө.

4. Эл хошууд өөрчлөлт хийхэд хүрвэл Хүрээний засгийн ордноос чадах чинээгээр тусламж үзүүлнэ.

5. Өвөр Монголын ард иргэд бас Хүрээний засгийн ордонд тушаал хариуцаж, ар монголчуудтай адил тэгш эрхийг эдэлж болно.

6. Аливаа гааль түрээсийг бүр ар Монголынхтой адил байлгаж үл хүндрүүлнэ.

7. Хүрээний засгийн ордон нь өвөр Монголын амарыг хамгаалах хариуцлагатай. Иргэн улс хэрэв дарлахад хүрвэл засгийн ордон заавал цэрэг явуулж хамгаална.

8. Дээрх зүйлийг Хүрээний засгийн ордоныг аядан дагасан тэр өдрөөс эхлэн хүчинтэй болно хэмээсэн байна.[28] Богдын засгийн газраас монгол үндэстнийхээ хүчийг нэгтгэх үүднээс явуулж байсан энэхүү бодлого, үйл ажиллагааг «Хаант Оросын санаагаар зохиож, гаргасан» зүйлс хэмээн Хятадын эрдэмтэд гуйвуулсан байна.[29]

28. Монгол үндэстэний нэвтэрхий түүх 3 дэвтэр, Доорд дэвтэр Өвөр Монголын нийгмийн шинжлэх цхааны хүрээлэнгийн түүх судлах газар, 1995 он, х.1985-1986

29. Монгол үндэстэний нэвтэрхий түүх 3 дэвтэр, Доорд дэвтэр Өвөр Монголын нийгмийн шинжлэх цхааны хүрээлэнгийн түүх судлах газар, 1995 он, х.1985-1986

"Гадаад Монгол тусгаар тогтнох журмыг үүсгэсэн нь бүх Монгол овогтон нийлэн хүчирхэг улс болохын зорилготой"[30] хэмээн Магсар хурц бичсэн буй. 1911 оны 12 дугаар сарын 29-ны өдөр Монгол Улсын эзэн хаанаар Богд Жавзандамба хутагтыг өргөмжилөн, туурга тусгаар улсаа тунхаглан зарласан нь "олон монголчуудын итгэж бишрэх нийтийн санаанаас гарсаны тулд" нийт монгол овогтон эл түүхэн үйл явдалыг талархан хүлээн авсан төдийгүй Монгол Улсын Богд хааны соёлд дагаар орж эхлэв. Эл тухай болон тусгаар тогтнолоо тунхаглан зарлаж, төр улсаа сэргээн байгуулсаны дараах үеийн Монголын хил хязгаар хэр зэрэг тэлж байсан талаар Магсар хурц өгүүлсэн буй.

Монголын харьяат газар орноо бүрэн бүтэн болгон эзэлж авахад нэн тэргүүн Улиастайд суусан манж хятадын сайд жанжин түшмэлийг хөөн гаргахаар Засагтхан, Сайн ноён хоёр аймгийн чуулганы дарга тэргүүд түүгээр зөвлөлдөж халхын 86 засаг хошууны нэр хамт бичиг явуулж байсаны зэрэгцээ Богдын засгийн газраас гүн Дэмжигванжил, түшмэл Балданцэрэн нарыг томилон гаргаж Улиастайд одуулан хятад жанжин сайд, түшмэл бүгд 45 хүн ба дагалдан суусан тэдний харьяат цэргүүдийн зэр зэвсгийг хураан авч Монголын хязгаараас хөөн зайлуулжээ. Улиастайд байсан албаны юм зүйлийг байцаан хурааж, монголчууд засгийн эрхээ[31] барьсан тухай дээр нэгэнтээ өгүүлсэн билээ.

Богдын Засгийн газарт дагаар орохоо илэрхийлэн Хөлөн бойр, газрын Өөлэд Солон баргын бүгдийн дарга Савандо, Цэнз, Батахи Янтафу Бүдгэрэл нараас ерөнхийлөн шийтгэх газрын нэр дээр хүргэн ирсэн бичгийн дотор "Өвлийн дунд сарын шинийн 9-нөө Богд хааныг эрдэнийн сууринд залж суулгах зэргийн явдлыг мэдэж манай олон бүгдээр чин үнэнээр бишрэн олон гар хошуудад бичиг явуулж түшмэл цэргийг цугларуулан харьяат газрын хятад түшмэл цэргүүдийг өвлийн дунд сарын 27-ны өдөр нэгэнт хөөн гаргаж газар орныг эзлэн авсан зэрэг учрыг гаргаж Богдын соёлд дагаар ирэх явдлыг төлөө сонсгон айлтгахыг гуйсугай"[32] хэмээн өгүүлсэн байна. Уг хүсэлтийг Богд хаан хүлээн авч, зарлиг буулган, энэ зүйлийн бичгийг хүргэж ирсэн шинэ барга, Шулуун цагаан хошууны гутгаар сумын занги Дамдинсүрэнд

30. Н.Магсаржав. Монгол Улсын шинэ түүх, УБ., 2010 он.
31. Н.Магсаржав. Монгол Улсын шинэ түүх, УБ., 2010 он.
32. Н.Магсаржав. Монгол Улсын шинэ түүх, УБ., 2010 он.

улсад туслагч гүнгийн зэргэ бусад дагалдан ирсэн зэргэтэй, зэргэгүй хүмүүст 5 дугаар зэргээс дэд зэргэ хүртэл жинс зэргэ шагнаснаас гадна мөн гүн Дамдинсүрэнг Гадаад яамны дэд сайдад тохоон тавьжээ.

Мөн зэргэлдээ орших харчин Мухар гашуун зэрэг өртөөг захирах залангийн занги Сандаг, Зааримагтай зэрэг өртөөг захирах залангийн занги Дониддорж нараас өөр өөрийн харьяат өртөөний албан дагнах, Өвөр Монгол овгийн ард нарыг авч дагаар ирсэн тухайд тус тус хишиг хүртээж улсад туслагч гүнгийн хэргэм шагнан хошуу зохиож, Түшээт хан аймагт хавсруулан захиргасан хожидхон дагаар ирсэн харчин Болодай зэрэг өртөөний ард нарыг дур саналыг дагуулан Жавзандамба хутагтын харьяат Их шавьд хавсруулан захируулсанд өмнө дурьдсан Харчин хоёр хошуу мөнхүү их шавьд нийлэн захируулахыг хүсэж мэдүүлэн нэгэн лүгээ адил хавсруулан захируулжээ. Бас үүний урьд дагаар орох бичгээ гаргаж өгсөн Хөвсгөл нуурын Урианхайн бүгдийн дарга Хишигжаргалд улсын түшээ гүнгийн хэргэм шагнаж харьяат урианхайн ардыг захируулан үст албан бариулж, ерөнхий захиргааны хэргийг Дотоод яаманд хавсарган эрхэлж явуулвай хэмээжээ.

Энэ мэт дагаар ирсэн Дариганга адуу, тэмээн сүргийн бүгдийн дарга Содномдовдонд улсад туслагч гүнгийн хэргэм, хонин сүргийн гарын дарга Магсаржавт тэргүүн зэргэ, мөн дагалдан ирсэн зарсан гарын даргын зэрэг түшмэдийг тус тус зэргэ дэвшүүлэн шагнаад мөн Даригангын зүүн баруун адуу, зүүн баруун тэмээ хонин сүрэг хэмээх таван гар хошуудыг Хөлөнбойр газрын Солоон Барга, Өөлэд таван гар хошууны хууль ёсоор зэргэ дэв олгуулсан байна.

Энэ завсар Богдын Засгийн газраас улс орныхоо амгалан тайван байдлыг хангах зорилгоор өмнө зүгийн буухиа өртөөний Сайр ус зэрэг өртөө болон умар хязгаарын Хиагтад суусан хятад заргач нарыг тусгай түшмэл цэрэг гаргаж хөөн явуулаад, Сайр Усны заргачийн орон тоог устгаж, Хиагтын харьяат худалдааны иргэдийн хэргийг захирах монгол түшмэлийг томилон илгээжээ. Богдын Засгийн газрын Дотоод, Цэргийн яамнаас эрхлэн удаа дараа айлтгаж Улиастай, Ховдын харьяат захирсан газруудыг илбэн тохинуулж ерөнхийлөн захирах сайдад гүн Гончигдамбыг томилон, басхүү Халхын дөрвөн аймгаас цэрэг дайчилж хойд хязгаарыг төвшитгэн тохинуулахаар мордуулахад харьяат

цэргийг захирах жанжин сайдад барга гүн Дамдинсүрэн халхын гүн Магсаржав нарыг томилон илгээсэн нь Монголын 2 дугаар он 6 сард европийн 1912 он 8 сарын 6-ны өдөр харьяат монгол жанжин сайд гүн Дамдинсүрэн, Магсаржав нар онц баатарлаг тэргүүлж цэргийн хүчээр байлдан Ховд хотыг дайчлан тохинуулж авсан учирт Богд хааны зарлигаар Дамдинсүрэнд манлай баатар жанжин цол засаг төрийн бэйлийн хэргэм, Магсаржавт хатанбаатар цол, бэйсийн хэргэм бас бус дагалдан явсан түшмэл цэргүүдийн гавьяа зүтгэлийг үзэж дэс дараалан жинс зэргэ цол шагнах зэргээр хөхүүлэн хөгжүүлжээ.

Өвөр Монголын бүгд 49 хошуунаас лав 38 нь Богдын Засгийн газарт сайн дураар дуртайяа дагаар орохоо илэрхийлсэнийг Монголын эрдэмтэн Магсар хурц, академич Б.Лхамсүрэн, Өвөр Монголын эрдэмтэн Өргэдэй Тайбун нар бүтээлдээ бичжээ. Энэ бол үнэндээ Өвөр Монголын хошуудын талаар л тэмдэглэсэн хэрэг үнэн хэрэгтээ Богдын соёлд дагаар орохоо илэрхийлсэн нийт монгол хошуудын тоо 60 шахам болсон хэмээн эх сурвалжид тэмдэглэсэн буй.

Богдын соёлд дагаар орсон эдгээр хошуудын нэрсийг Магсар хурцын бичснээр тодорхойлвоос,

Өвөр Монголын Шилийн голын чуулганы ноёд уг Монгол лугаа нийлж нэгэн гэрийн улс болохыг зөвшилцөн байсны дотроос нэн түрүүн хуучдын зүүн засаг ван Сэлнэнтожилоос харьяат хошууны 7 сумын бүгд 323 өрх, 1491 ам хүнийг авч “бүгдээр харанхуйн дотроос тонилж сая гэрэлт нарын лугаа учирсан адил магад дуртайяа сүслэн шашин төрийг хослон баригч наран гэрэлт түмэн наст Богд хааны соёлд багтаж тулгар төрийг дагаар орж хүчин зүтгэсүгэй” хэмээн бичиг барьж биеэр бараалхан мөргөөр ирснээс эхлэн дотоод 6 чуулганы зэрэг олон монгол овогтон дараа дараагаар Богд хааны соёлд хандаж монгол улсын төрийг дагаар орохыг батлан есөн цагаан өргөж элч бичиг илгээсэн удаа бүр тодорхойлон байлдаж зарлигаар явуулсныг нэрлэж илтгэвээс дээр дурдсан Шилийн голын чуулганы зүүн хуучдын ван Сэлнэнтожилын нэгэн хошууны дээр мөн чуулганы Хуучидын баруун засаг жүн ван Сандагдоржийн нэгэн хошуу, Авгын зүүн засаг чин ван Янсангийн нэгэн хошуу мөн Авгын баруун засаг гүн Зэнэмэдэрийн нэгэн хошуу, мөн Үзэмчиний зүүн засаг бэйл Гомбосүрэнгийн нэгэн хошуу мөн

Үзэмчний зүүн засаг бэйл Гомбосүрэнгийн нэгэн хошуу мөн Үзэмчний баруун засаг чин ван Сономравдангийн нэгэн хошуу мөн Сөнидийн баруун засаг жүн ван Дэмчигдонровын нэгэн хошуу, Авганарын зүүн засаг бэйл Цэрэндоржийн нэгэн хошуу мөн Авганарын баруун засаг бэйл Содномноровын нэгэн хошуу бас Жиримийн чуулганы засагт чин ван Удайн нэгэн хошуу, бинт чин ван Дамбадоржийн нэгэн хошуу, Ерөөлт чин ван Рашминжүүрийн нэгэн хошуу, чин ван Амарлингуйн нэгэн хошуу, жүн ван Нарангэрлийн нэгэн хошуу, засаг тайж Пунцагийн нэгэн хошуу, Жалайдын жүн ван Бадамравдангийн нэгэн хошуу, мөн чуулганы ноён хутагт Лувсантүвдэнжалсан, Өлзийт мэргэн хамба Дэнзэнишпэрэнлэйнамжил нар өөр өөрийн шавь нарын хамт бас Зуу-Удын чуулганы Ороцоны засаг бэйл Базарсадын нэгэн хошуу Бааринги́йн Бэйс Сандагнамжилванбуугийн нэгэн хошуу мөн Бааринги́йн ван Жагарын нэгэн хошуу, Жаруудын бэйл Лхаваанбалжидын нэгэн хошуу, дархан бэйс Товуучийн нэгэн хошуу, Хишигтний засаг Банзайн нэгэн хошуу, бас их Зуугийн чуулганы дарга чин ван Арвинбаярын нэгэн хошуу, дэд чуулганы дарга жүн ван Чагдарсэрэнгийн нэгэн хошуу, Ордосын баруун засаг жүн ван Галсанроломванчинжамцын нэгэн хошуу мөн бэйл Сүмбэрбатын нэгэн хошуу, мөн гүн Чагдаржавын нэгэн хошуу, Улаанцавын чуулганы дарга чин ван Лхаваанноровын нэгэн хошуу дэд чуулганы дарга дархан чин ван Юндэнванчигийн нэгэн хошуу, Урадын өмнөд засаг бэйс Хишигдэлгэрийн нэгэн хошуу, Дундад засаг гүн Бавуудоржийн нэгэн хошуу хойд засаг бэйс Раашнамжилдоржийн нэгэн хошуу, бас Зостын чуулганы Харчин ван Гүнсэннорвын нэгэн хошуу, жүн ван Сандагнамжилванбуугийн нэгэн хошуу, үүнээс дээш Шилийн голын чуулганы 10 хошуу бүх чуулганаар Жиримийн чуулганы 6 хошуу, хоёр ламын шавьтай Зуу-Удийн чуулганы 6 хошуу, Их Зуугийн чуулганы 5 хошуу, бүх чуулганаар Улаанцавын чуулганаас 6 хошуу, Зостын чуулганаас 2 хошуу энэ бүгд өвөр 6 чуулганы 49 хошуунаас 35 хошуу нь янагш хандаж байсан ба бас цахар зүүн гарын хөвөөт шарын хошуу, мөн хонин сүргийн хошуу, Хөвөөт цагаан хошуу, Шулуун хөх хошуу, Шулуун цагаан хошуу, үхэр хонин сүргийн хошуу, цахар баруун гарын Хөвөөт хөхийн хошуу, Сант адуун сүргийн хошуу эдгээр цахар 8 хошууг мөн цахарын Гүүширмэргэн хамба хутагт Лувсан-Осоржамц тэргүүлэн жолоодож дагаар иржээ.[33]

33. Н.Магсаржав. Монгол Улсын шинэ түүх, УБ., 2010 он.

Бас дээр дурьдсан Ховд хязгаарыг төвшитгөн тохинуулахаар гаргасан жанжин сайдуудад туслан явсан жалханз хутагт Дамдинбазарын дөрвөд 2 аймгийг дагаар оруулахаар урьсанд дуртайяа дагаар ирсэн Дөрвөдийн Төгсхөлөгдалай хан Галсаннамжилын нэгэн хошуу, жүн ван Түгээмэлийн нэгэн хошуу, жүн ван Самданжамцойн нэгэн хошуу, бэйс Цэнджүннэйн нэгэн хошуу бэйс Нацагдоржийн нэгэн хошуу, гүн Түмэнбаярын нэгэн хошуу, гүн Очирын нэгэн хошуу, гүн Түдэвийн нэгэн хошуу засаг Сэнгэдоржийн нэгэн хошуу, засаг Раашийн нэгэн хошуу, засаг Бадамын нэгэн хошуу, засаг Дандарын нэгэн хошуу, эдгээр 12 хошуу, Дөрвөдийн баруун гарын чин ван Содномжамцойн нэгэн хошуу, мөн жүн ван Түмэнжаргалын нэгэн хошуу, бэйс Баатарын нэгэн хошуу, гүн Аюурзанын нэгэн хошуу, эдгээр 4 хошуу, бас дагалдаагаар захчины өрнөд засаг бэйс Цэрэндоржийн нэгэн хошуу, дорнод засаг гүн Самбуугийн нэгэн хошуу, мөн захчины Алтай Урианхайн засаг гүн Цагаанбилигийн нэгэн хошуу, эдгээр 3 хошуу, бас Алтайн Урианхайн засаг гүн Төрбатын нэгэн хошуу, гүн Ядамжавын нэгэн хошуу, гүн Сэндэнжавын нэгэн хошуу, гүн Ламжавын нэгэн хошуу, гүн Очиржавын нэгэн хошуу, гүн Гомбожавын нэгэн хошуу, гүн Галсанжавын нэгэн хошуу эдгээр 7 хошуу, бас Торгуудын чин сэтгэлт аймгийн чуулганы дарга чин ван Мишигдонровын нэгэн хошуу, дэд чуулганы дарга засаг бэйл Магсаржавын нэгэн хошуу, засаг гүн Өлзийн нэгэн хошуу эдгээр 3 хошуу, Хошоодын засаг гүн Дамдинцэрэнгийн нэгэн хошуу, бас Ар Илийн цахарын дэд дарга Сумьяагийн нэгэн сум, Танну-ын харъяат Салчиг, Тож хоёр Урианхай, Хасаг, Сүхэрбай Хуанган, Хьюбай Хлан зэрэг хэсэг хэсэг ардууд удаа дараа цутган дагаар ирсэн тухай бүр хүлээн авч угаас хэргэм зэргэ бүхий ноёд түшмэд тэргүүлэгчдийг зэргэ дэвшүүлэн цол, хэргэм жолоо шагнан отго жинсгүйд зохих отго жинс лам нарт янба цол олгуулах зэргээр хөхиүлэн шагнасан болохын дээр тэдгээрийн хошуу захиргааны тухай болбаас язгуураас захирсан хошуу эзэлсэн нутаг бүхий дотоод 6 чуулганы ноёдод өөр өөрийн хошууг хэвээр захиран шийтгэх эрх тушаалыг батлан уг газар орныг сахин хамгаалах учир буу зэвсэг талбин олгуулж тусламж үзүүлсэн газар бүхий ба хааяа уул газраас ам бүл нарыг авч улс төрд биеийн хүчин зүтгэсүгэй хэмээн Нийслэл Хүрээний зэрэг газар нүүж

ирэгсдийн идэр залуусыг цэрэг элсээж хороо байгуулан цалин амуу олгуулж суулгасан хэмээн Магсар хурц тэмдэглэжээ.

Дээр дурьдсан Богдын засгийн газарт дагаар орохоо илэрхийлсэн монгол олон хошуудын хэдэн арван өргөдөл шар торго болон муутуу цаасан дээр бичиж өргөн барьсан нь эдүгээ хүртэл архивт хадгалагдан үлджээ. Тухайлбал, Зостын чуулганы Харчин дундад хошууны үе улиран залгамжлах дөтгөөр зэрэг тавнан Хишигтээс Монгол Улсын Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яаманд 1912 оны 1 дүгээр сарын 20-нд өргөсөн бичигт өгүүлэхдээ: “Манай харьяат гүн ноён, түшмэл нийтээр соёлд багтан хүчин зүтгэхийг шуудсан боловч иргэн хятадын зах залгалдан суух бөгөөд олонд өглөө, үдэшийн зовлон хоцоргохоос айн болгоомжлон бүхийн тул өчүүхэн Хишигт би урьдаар Богд хааны соёлд багтаж, морь, нохой мэт зүтгэж, хүчээ өргөхийг хичээн хөвгүүн дөтгөөр зэрэг тавнан Жаргал, эм, хөвгүүд, гэр бүхнийг авч сэмээр гарч ирсэн учраа илтгэн гаргаж Их яамнаа өргөн мэдүүлээд олдвоос боолын морь, нохой мэт зүтгэж, хүчээ өргөсүгэй хэмээх үнэн санааг уламжлан айлтгаж, хүчлэн зүтгүүлэх ажаам уу” хэмээжээ.

Мөн Өвөр Монголын Шилийн голын аймгийн Баруун гарын хуучид хошуунаас гаралтай Гарчидын Дивасамбуу[34] лам гуай -2010 оны 12 сарын 3-ны өдөр хуучлахдаа: “Богдыг монгол хүн бүр их шүтэж, айл бүрт төмөртэй зураг нь байв. Богдыг хамгийн их дээдэлдэг байсан. Цагаан сарын шинийн нэгний өмнө элсэнд мөргөнө гээд бөөн юм болдог. Өглөө эрт баруун урагш, сүүлд баруун хойшоо мөргөдөг болсон юм гэнэлээ. Учир нь Богд эзэн хаан суусэн учир тэр зүгт мөргөж

34. Дивасамбуу лам гуай Улаанбаатар хотноо Гандантэгчэнлин хийдийн цорж лам, гавж. Тэрбээр Шилийн голын аймгийн Буруун хуучид хошууны Өргөн сумын Багсум тайжын харьяат Далай овогтой Гарчидын ахмад хөвгүүн бөгөөд 1928 онд төржээ. Шилийн голын аймгийн Авга нар зүүн хошууны бандид гэгээний хийдэд аавын хамт сууж байжээ. Түүний аав Гарчид хийдийн сойвон, өөрөө энгийн лам байжээ. 1945 онд Японы эсрэг дайнд орсон орос цэргүүдийн үйл ажиллагааны улмаас уул нутаг –Баруун хуучид вангийн хошуугаа орхин Сэцэн хан аймгийн Төв засгийн хошуу одоогийн Сүхбаатар аймгийн Зотол буюу Эрдэнэцагаан сумын нутаг Рашаан далай булаг гэдэг газраар 200 шахам өрх айл мал сүрэг хөрөнгийн хамтаар олон арван үхэр тэргээр нүүдэллэн иржээ. Бурханы олон шавь нар нийлэн Өндөр хамрын хийдээ Сүхбаатарт нээн байгуулж, үйл ажиллагаа явуулж, улмаар Гандан хийдтэй холбогдон хурал номын ажлаа явуулж байв. Тус хийдийн унзад болж, бичиг хэргийг бүхий л ажлыг Дивасамбуу гуай хийж байжээ. Улмаар уг хийд 1960 онд Гандантай нийлж, уул дацангаас ловон лам Намжил, -гэсгүй Жамбал Хайдав, умзад Дивасамбуу, шавран Ваанчиг нар Ганданд ирж суужээ. Гандангийн нярав, даамал, гэсгүй, Шашны дээд сургуулийн багш,, лам, хурлын ловон, цорж лам хийсээр эдүгээ хүрчээ. Их Мэгзэджанрайсиг бурханыг сэргээн бүтээхэд бурханы шүншүгийн удирдан хийлгэсэн учир Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Алтан гадас одонгоор шагнагдсан байна.

буй хэрэг. Харин монгол тусгаар тогтнож, бүх монгол овогтон нэгдвэл зүгээр гэж Богд айлдсан байна. Ингээд Өвөр Монголын олон хошууны ноёд бүгд Богдыгоо дагана гэсэн. Хойтон хавар нь Монголоос хүмүүс ирээд бүртгэх гэсэнд энэ хооронд Хятадын Юанши кай монгол ноёдыг цааш пүнлүүгээр урхидаж амжжээ. Ингээд Цэрэнтожил ван би Богдыгоо дагана гээд 80 өрхтэйгээ Монголд ирсэн гэдэг. Энэхүү Цэрэнтожилын хүүхдүүд бий. 2007 онд түүнд зориулан суврага босгосон юм" хэмээн ярив. Бас Дивасамбуу гуайн дурссанаар " Урьд дүрийн Хуучид хамба Лувсан Түвдэн Жанцан гэдэг лам тусгаар Монгол Улсын Богд хаан Жавзандамба хутагтыг 1914 онд эрж ирэн мөргөөд танай улсыг дагая гэхэд Богд хаан зөвшөөрч, хуучин мэргэд хамбад ямба нэмэж олгоод 50 лангийн мөнгөн тамга хайрлажээ. Тэрхүү тамганы дээр "Хуучид мэргэн хамбын шавь нарыг захирах тамга" гэсэн үсэгтэй байсан"[35] байна.

"1912 оны эхээр Өвөр Монголын харчин ван Гүнсэнноров "Өвөр Монголын нэгдсэн байгууламж байгуулж", 6 дугаар сард гэрээний дагуу буу зэвсэг тээвэрлэж байх замдаа Хятадын талд мэдэгдээд, Хятадын цэрэгтэй мөргөлдөөн гарч, дарагдан энэ удаагийн ажиллагаа нь ялагдлаар төгсөв. Энэ хэргийг Японд "нэгдүгээр удаагийн манж, Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн"[36] ч гэж хэлдэг тухай Тохоку их сургуулийн докторант Улаантана бичжээ.

1912 оны 8 дугаар сараас 12 дугаар сарын сүүлч хүртэлх таван сарын хооронд Өвөр Монголд энд тэндгүй өргөн хэвчээгээр бослого гарч байв. Жишээлбэл, 8 дугаар сард Жирэмийн чуулганы хорчин баруун гарын өмнөд хошууны засаг Удай ба Жирэмийн чуулганы хорчин баруун гарын хойд хошууны засаг Рашминжүүр нар бослого гарган, дарагдсаны хойно Халхад хүрэлцэн очив. Түүний дараа Зуу Удын чуулганд ч бас бослого гарч байв. Эдгээр бослого нь Богд хааны засгийн газартай холбоотой байсан учраас Японы анхаарлыг ихэд татаж байлаа. Учир нь 1912 оны 7 сард Орос Японы гэрээгээр дамжин Бээжингээр уртраг болгон, Япон Зүүн Монголыг өөрийнхөө нөлөөний хүрээнд оруулаад, Өвөр Монголд гарч байсан хэрэг явдал,

35. Уулын баруун хуучид хошууны товч түүх, Думдад улсын Ардын улсын төрийн зөвөлгөөний Шилийн хотын хорооны соёл түүхэн материалыг эмхтгэж найруулах комисс, 2006 он, х.235

36. Улаантана Богд хааны Засгийн газар байгуулагдсаны дараах Монголын хэрэгт холбогдох Япончуудын цуглуулсан мэдээний эх сурвалж, - "Монгол түүхийн судлал ба сурвалж" эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл 2009.09.20

ялангуяа Оростой нягт холбоотой байсан Богдын Засгийн газар болон Өвөр Монголын хоорондох харилцаа нь японы анхаарлаас гадна байж чадаагүй юм.[37]

Тэгвэл Ар Монголд ноёд, лам, хар цөмөөр үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэлд өөр өөрийн хувь нэмрийг оруулахыг сэтгэлийн угаас хичээж байжээ. Тухайлбал, Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны харьяат Шагдар: "автономит засгийг байгуулах үед Ар Хиагтын газраас гурван түмэн бирдан бууг нэгэн живаа таван сая сумын хамт нийслэл Хүрээнд нууцаар оруулах явдалд миний бие голлон оролцож, хувийн хоёр зуун тэмээдийг хэрэглэсэн, мөн тэр хавиас тэмээ үхэр олж ачих зэргээр Чин улсын харгис эрүү шүүлт ба толгой авах хүнд цаазаас айлгүй өөрийн монгол үндэстнийг тусгаар эрхт улс болох их хэрэгт амь биеийг хайрлалгүй зүтгэсэн гавьяаг илэрхийлэн гүн зэрэг шагнагдсан ба дараа нь шинэ засгийн санхүүд түмэн лан мөнгө тусалсан учир бэйсийн зэрэг тус тус шагнагдсан "[38] хэмээн 1932 онд бичсэн өргөдөлдөө бичжээ.

Энэ бүгд зуун жилийн өмнөх олон монголчуудын байдал ямар байсан хийгээд Богд хааны нэр сүр, суу алдар ямар байж, түүнд хэрхэн хандаж ирснийг тодорхой харуулж байна хэмээн санамой. Үүний дотроос тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөө, төр улсаа сэргээн байгуулсан Монголын Улсын Богд хааны засгийн газар буюу Хүрээний зүгт монгол овогтон суугаа газар бүрээсээ жил бүрийн цагаан сарын шинийн нэгний өглөө өвдөг сөхрөн мөргөж, дотроо монголынхоо гал голомтонд залбирч байсан нь чухам монголчуудын үнэн түүх ажээ.

Богд соёлд дагаар орсон өвөр монголын хошуудын захирагч нараас Засгийн газарт цөөнгүй хүмүүс дэд сайд, түшмэлийн алба хашиж байсан билээ. Тухайлбал, Баргын Цэнд гүн, Хайсан гүн, Удай ноён гэжд олон хүмүүсийг нэрлэж болно.

---

37. Улаантана Богд хааны Засгийн газар байгуулагдсаны дараах Монголын хэрэгт холбогдох Япончуудын цуглуулсан мэдээний эх сурвалж, - "Монгол түүхийн судлал ба сурвалж" эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл 2009.09.20

38. С.Ичинноров. Монголын нэгэн тэргүүн баяны өргөдөл-Монгол хоршоо, Монголын үйлдвэрлэл үйлчилгээний хоршоологчдын хэвлэл, 1990.11.6-22, Дугаар 3, Л.Гомбожав Хичээн зүтгэсний хүчинд баяжжээ. Бөөгийн Шагдарын тухай-мөн сонинд

Ар Илийн Цахар Сумьяагийн харьяат 100 илүү өрхийн хүмүүсийг Хиагтын баруун талд хошуу зохион нутаг үндэс заан олгож Түшээтхан аймагт хавсарган захируулсан буй. Танну-ын харьяат Салчиг Тож хоёр Урианхайг дур саналыг дагуулан Засагтхан аймгийн Жалханз хутагтын шавьд хавсарган захируулав. Хасаг Сүхэрбай, Хуанган, Хьюбай, Хлан нарт тус тус гүнгийн зэргэ шагнаад өөр өөрийн дагалдсан хасгуудыг тэргүүлэн захируулж дараа нутагт үндэс олгож тохинуулахын янар аль болох зохих нутагт найртайгаар нутаглуулан аж төрүүлэх зэрэг явдлыг Ховдод хэрэг шийтгэх сайдын газраас эрхлэн захирч явуулахаар тушаал гаргаж Дотоод яамнаас бичиг явуулсан байна.

Тэр мэтээр Монгол улс дахиж мандахын шинж лавтай ургаж дорно зүгийн Хянганы уулаас баруун этгээд Алтайн нуруу хоёрын хооронд бүхий газар усаар эзэлсэн бүрэн эрхт Монгол Улс болон мандаж байсан үнэн магад байдлыг түүхнээ тэмдэглэх нь зүйд нийцнэ хэмээн бодно. Өөрөөр хэлбэл энэ үеийн Монгол Улсын газрын зураг нилээд өргөн, гүн агуулгатай байжээ хэмээн үзэж болохоор буй.

Хөх нуурын зүүн гарын чуулганы дарга бэйс Хүрэлгээс Хөх нуурын 24 засгийг төлөөлөн “газар орны гачигдалтай байдлыг гарган Богдын соёлд багтаж бурхан шашнаас хэзээд хагацахгүй аргыг заана уу” хэмээн хоёр гарын чуулганы даргын тамга дарсан бичиг барьж биеэр ирсэнд харьяат 24 засгийн хэргэмийг нижгээд зэргэ дэвшүүлэн шагнаж газар нутгийг хамгаалах хурдан сайн буу 100, сум 3 түмийг олгож буцаасан[39] тухай эх сурвалжид тэмдэглэжээ.

Бас Хөх нуурын Жүн ван Намданчойнхор Хөхэд бэйл хөвгүүн Лхаваанраашиг нар Богдын соёлд багтсугай хэмээн бичиг өргөж биесээр бараалхан мөргөхөөр ирсэн удаатай аж.

Дээр өгүүлсэн Богдын соёлд дагаар орохыг хүссэн хошууд бол цөм монгол гаралтай угсааны хошууд болой.

39. Н.Магсаржав. Монгол Улсын шинэ түүх, УБ., 2010 он.

ДҮГНЭЛТ

1911 онд Монголчууд Манж Чин гүрнээс салж, тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан явдал бол монголчуудын түүхэнд шинэ эрин үеийг нээсэн билээ. VIII Богд Жавзандамба хутагтыг хаанд өргөмжилсөн нь Монгол туурга тусгаар улс болсоны шинж тэмдэг болсон төдийгүй олон монголчуудын итгэл бишрэлийн илэрхийлэл болсон юм. Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хааны сэнтийд өргөмжлөөд, улсын цолыг Монгол, оны нэрийг Олнаа өргөгдсөн, Их Хүрээг Нийслэл Хүрээ хэмээн нэрийдэж, XX зууны эхээр Ази тивд Монгол улс сэргэн мандсаны шинэ түүх эхэлжээ.

Энэ бол Монгол төр улсаа сэргээн байгуулж, тусгаар тогтносон, бие даасан улс болсноо дэлхий нийтэд албан ёсоор тунхагласан өдөр юм. Монголчуудын амьдралын сүүлийн 300 жилд тохиосон түүхэн онцгой үйл явдал лав энэ мөн гэж үзэж байна. Энэ өдөр бол эртний монголын эзэн Чингисийн байгуулсан төрийн гал голомт сэргэсэн өдөр гэж үзвэл зүйд нийцнэ гэж бодож байна. Энэхүү 1911 оны үндэсний хувьсгал өөрөө амжилтад хүрсэн нэг гол учир шалтгаан нь бүх монгол овогтон үндэсний үзлээрээ нэгдэж, нэгдмэл нэг зорилгын төлөө бурханы шашныхаа тэргүүнийг хүрээлж, түүхэн амжилтад хүрсэн билээ.[40] Энэхүү үйл явдлаас хойш Монголд XX зууны турш өрнөсөн түүхийн үйл явдлууд нь 1911 онд сэргээн тунхагласан Монголын төр улсаас улбаатай болохыг энд хэлэхэд илүүц бус болов уу.

Чухамдаа түүхэн ач холбогдлоор нь авч үзвэл 1911 оны үндэсний хувьсгал нь монголын гал голомтыг сэргээн бадрааснаараа, монгол үндэстэний цаашид оршин байх үндэсийг тавьснаараа, үндэсний уламжлал, зан заншил, соёлыг бадруулах үндэс болсноороо монголчуудын амьдралд онцгой чухал байр суурь зүй ёсоор эзлэх учиртай.

Чухамдаа 100 гаруй жилийн тэртээ бидний өвөг дээдсийн хийсэн ухаалаг бодлого, шийдвэртэй алхамын хүчээр эдүгээгийн Монгол хөгжихын үндэс тавигдсан хэмээн үзэж буй билээ.

---

40. О.Батсайхан. Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог, Хоёр дахь хэвлэл, УБ., 2011 он, 603 дахь тал.